



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өгийнуур сумын ЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2026/139/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mnp Эрдэнэбулган хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Цахим актив аудит ХХК: Аудитор: Д.Эрдэнэцэцэг Утас:99019943 Цахим хаяг: tsakhimactive@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨГГИЙНУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Х.НЭРГҮЙ ТАНАА

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.02.25 № 113
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Өгийнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Ерөнхий гэрээгээр жагсаалтад орсон эм эмийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 2,291.4 мянган төгрөг,
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй,
- НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй,
- Орон нутгийн санхүүжилтээс 12,585.5 мянган төгрөгийг орон сууцны засвар гэж хувь хүний данс руу анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажлын гүйцэтгэл байхгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байхад шилжүүлсэн,

- Автомашин засварлахаар (техникийн дүгнэлтгүй) 8,942.0 мянган төгрөгийг сэлбэг нийлүүлэх гэрээ хийж, хувь хүний данс руу шилжүүлсэн ч ажлын гүйцэтгэл байхгүй, ямар машин засварласан нь тодорхойгүй,

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 16 дугаар зүйлийн 16.5.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.15.2 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 23 нэр төрлийн 15,659.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан, 22,849.6 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 5,090.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлогоор, 11,500.4 мянган төгрөгийн акталсан хөрөнгийн дахин үнэлгээ хийж хөрөнгө нэмэгдүүлсэн, хөрөнгийн капиталжуулсан зардалд 29,200.0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн төв нь тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 14201 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлснээр Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 1,357,443.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 75,447.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч үйл ажиллагаандаа зарцуулж, төрийн сангийн харилцах дансанд 26,162.2 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлэгдэлтэй байна.

Тайлант онд шүдний кабинетийг 1 их эмч, 1 сувилагчтайгаар, 49,695.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжтэй байгуулж давхардсан тоогоор 150 гаруй хүнд анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж 1,729.5 мянган төгрөгийн зардал гаргаж, 3,350.0 мянган төгрөгийн орлого олж шүдний материал худалдан авахад зарцуулсан байна.

Тайлант онд эм, эм боох материалын 45,496.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 36 нэр төрлийн 3,096.6 мянган төгрөгийн нөөцийн эм, 3354 нэр төрлийн 13,872.4 мянган төгрөгийн он дамжсан эм, эмийн хэрэгслийн үлдэгдэлтэй, 46 нэр төрлийн 28,527.5 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалын үлдэгдэлтэйгээр тус дансанд бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсөв захирагчаас 90.1 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	297,037,781.42	265,977,218.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,528,119.19	26,162,247.65
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	21,528,119.19	26,162,247.65
3121	Төгрөг	21,528,119.19	26,162,247.65
31211	Төрийн сангийн харилцах	21,528,119.19	26,162,247.65
33	АВЛАГА	126,931,535.75	103,565,573.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	416,939.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	126,931,535.75	103,148,634.00
35	БАРАА МАТЕРИАЛ	148,578,126.48	136,249,397.76
351	Түүхий эд материал	78,685,288.95	45,457,010.23
35130	Эм боох материал	78,685,288.95	45,457,010.23
354	Хангамжийн материал	69,892,837.53	90,792,387.53
35410	Бичиг хэргийн материал	4,414,180.00	7,098,030.00
35420	Аж ахуйн материал	56,132,157.53	71,926,857.53
35450	Барилгын засварын материал	9,346,500.00	11,767,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	732,401,034.46	699,244,011.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	732,401,034.46	699,244,011.13
392	Биет хөрөнгө	710,745,034.46	677,738,011.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	486,589,328.68	508,989,328.68
39202	Хуримтлагдсан элэгдэл	(96,711,377.07)	(117,108,278.07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,003,994.00	92,003,994.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(47,856,227.11)	(81,193,581.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	259,044,777.35	282,373,255.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,595,733.43)	(107,748,171.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,204,094.30	39,657,080.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,835,342.42)	(12,754,168.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	78,586,578.00	85,386,578.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,685,057.84)	(11,868,026.80)
393	Биет бус хөрөнгө	21,656,000.00	21,506,000.00
39301	Програм хангамж	1,800,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000.00)	(450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,156,000.00	20,156,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,029,438,815.88	965,221,229.54
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,029,438,815.88	965,221,229.54
51	Засгийн газрын хувь оролцоо	1,029,438,815.88	965,221,229.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	527,154,798.11	527,154,798.11
51101	Өмч: - төрийн	527,154,798.11	527,154,798.11
512	Хуримтлагдсан үр дүн	483,460,163.23	419,242,576.89
51210	Өмнөх үеийн үр дүн	483,460,163.23	483,460,163.23

51220	Тайлант үеийн үр дүн	-	(64,217,586.34)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	18,823,854.54	18,823,854.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,029,438,815.88	965,221,229.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,073,328,653.97	1,298,068,258.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,640,000.00	41,331,106.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,640,000.00	41,331,106.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,640,000.00	41,331,106.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,640,000.00	3,420,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		21,319,787.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн орлого		16,591,319.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,039,688,653.97	1,256,737,152.22
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,203,000.00	75,447,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,203,000.00	75,447,700.00
1330	Төсвийн захирагчдаас	-	62,532,974.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		62,532,974.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	968,485,653.97	1,118,756,478.22
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	968,485,653.97	1,118,756,478.22
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,052,219,840.26	1,362,285,844.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,052,219,840.26	1,362,285,844.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,045,897,848.18	1,272,412,224.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	640,193,107.00	779,624,174.00
210101	Үндсэн цалин	358,533,710.00	371,022,504.00
210102	Нэмэгдэл	217,984,539.00	316,809,363.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,073,363.00	35,304,025.00
210104	Урамшуулал	62,601,495.00	56,488,282.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,079,976.00	94,281,495.39
210201	Тэтгэврийн даатгал	58,536,332.33	68,417,191.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,984,963.75	6,507,072.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,988,124.00	3,214,567.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,703,419.00	3,150,084.38
210205	Эрүүл мэндийн даатгал	11,867,136.92	12,992,579.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,846,007.92	52,154,134.26
210301	Гэрэл, цахилгаан	5,993,600.72	9,148,984.82
210302	Түлш, халаалт	40,852,407.20	43,005,149.44
2104	Хангамж, бараа материалын зардал	45,192,358.09	44,484,830.00
210401	Бичиг хэрэг	6,437,800.00	6,143,850.00
210402	Тээвэр, шатахуун	26,592,940.00	29,477,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,685,000.00	2,975,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,980,000.00	45,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,496,618.09	5,843,500.00
2105	Нормативт зардал	131,452,626.71	172,402,647.75
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	113,842,466.71	148,597,029.75
210502	Хоол, хүнс	17,610,160.00	23,805,618.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,777,900.00	15,144,500.00
210604	Урсгал засвар	16,777,900.00	15,144,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,244,000.00	4,980,000.00
210702	Дотоод албан томилолт	3,244,000.00	4,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,660,701.00	4,852,501.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,729,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,700,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,860.00	93,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	135,000.00	81,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	172,000.00	1,439,700.00
210807	Газрын төлбөр	8,841.00	7,741.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	525,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,451,171.46	104,487,942.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,639,700.00	2,690,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,811,471.46	101,797,942.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,321,992.08	89,873,619.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	85,120,754.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	42,847,254.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	17,436,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	24,837,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,321,992.08	4,752,865.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,321,992.08	4,752,865.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,108,813.71	(64,217,586.34)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,108,813.71	(64,217,586.34)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	972,106,469.22	1,283,940,054.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,640,000.00	130,351,536.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,640,000.00	130,351,536.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,640,000.00	130,351,536.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,640,000.00	3,420,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		126,931,536.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	938,466,469.22	1,153,588,518.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	71,203,000.00	75,447,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	71,203,000.00	75,447,700.00
1330	Төсвийн захирагчдаас	-	62,532,974.00

133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		62,532,974.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	867,263,469.22	1,015,607,844.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	867,263,469.22	1,015,607,844.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	959,866,741.02	1,227,256,325.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	959,866,741.02	1,227,256,325.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	953,544,748.94	1,135,497,705.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	640,193,107.00	780,037,033.00
210101	Үндсэн цалин	358,533,710.00	371,435,363.00
210102	Нэмэгдэл	217,984,539.00	316,809,363.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,073,363.00	35,304,025.00
210104	Урамшуулал	62,601,495.00	56,488,282.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,079,976.00	94,281,495.54
210201	Тэтгэврийн даатгал	58,536,332.33	68,417,191.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,984,963.75	6,507,072.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,988,124.00	3,214,567.51
210204	Ажилгүйдлийн даатгал	2,703,419.00	3,150,084.53
210205	Эрүүл мэндийн даатгал	11,867,136.92	12,992,579.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,881,007.92	52,174,134.26
210301	Гэрэл, цахилгаан	5,993,600.72	9,148,984.82
210302	Түлш, халаалт	40,852,407.20	43,005,149.44
210303	Цэвэр, бохир ус	35,000.00	20,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,807,040.00	54,113,780.00
210401	Бичиг хэрэг	8,499,200.00	8,827,700.00
210402	Тээвэр, шатахуун	26,136,940.00	28,880,880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,685,000.00	2,975,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,980,000.00	153,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,505,900.00	13,276,600.00
2105	Нормативт зардал	103,527,317.02	117,196,662.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76,224,657.02	93,026,964.00
210502	Хоол, хүнс	15,445,160.00	17,659,698.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,857,500.00	6,510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,654,400.00	19,239,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	700,000.00
210604	Урсгал засвар	20,654,400.00	18,539,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,244,000.00	4,980,000.00
210702	Дотоод албан томилолт	3,244,000.00	4,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,660,701.00	4,852,501.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,729,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,700,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	119,860.00	93,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	135,000.00	81,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	172,000.00	1,439,700.00
210807	Газрын төлбөр	8,841.00	7,741.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	525,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,497,200.00	8,622,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,497,200.00	8,622,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,321,992.08	91,758,619.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	87,005,754.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	42,847,254.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	17,436,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	26,722,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,321,992.08	4,752,865.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,321,992.08	4,752,865.74
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,239,728.20	56,683,728.46
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	36,973,000.00	52,049,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	36,973,000.00	52,049,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	36,973,000.00	52,049,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	36,973,000.00	52,049,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(36,973,000.00)	(52,049,600.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(24,733,271.80)	4,634,128.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,528,119.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,528,119.19	26,162,247.65

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	527,154,798.11	18,823,854.54	483,460,163.23	1,029,438,815.88
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	527,154,798.11	18,823,854.54	483,460,163.23	1,029,438,815.88
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	527,154,798.11	18,823,854.54	483,460,163.23	1,029,438,815.88
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	527,154,798.11	18,823,854.54	483,460,163.23	1,029,438,815.88
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	527,154,798.11	18,823,854.54	483,460,163.23	1,029,438,815.88
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(64,217,586.34)	(64,217,586.34)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	527,154,798.11	18,823,854.54	419,242,576.89	965,221,229.54

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,432,891,400.00	1,271,133,059.54	161,758,340.46	11.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,432,891,400.00	1,271,133,059.54	161,758,340.46	11.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,343,345,200.00	1,184,127,305.54	159,217,894.46	11.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	852,756,300.00	780,037,033.00	72,719,267.00	8.5
210101	Үндсэн цалин	596,966,200.00	371,435,363.00	225,530,837.00	37.8

210102	Нэмэгдэл	162,557,100.00	316,809,363.00	(154,252,263.00)	(94.9)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,996,000.00	35,304,025.00	(28,308,025.00)	(404.6)
210104	Урамшуулал	86,237,000.00	56,488,282.00	29,748,718.00	34.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,080,300.00	94,281,495.39	10,798,804.61	10.3
210201	Тэтгэврийн даатгал	70,777,800.00	68,417,191.00	2,360,609.00	3.3
210202	Тэтгэмжийн даатгал	8,575,600.00	6,507,072.60	2,068,527.40	24.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,287,800.00	3,214,567.51	1,073,232.49	25.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,287,800.00	3,150,084.38	1,137,715.62	26.5
210205	Эрүүл мэндийн даатгал	17,151,300.00	12,992,579.90	4,158,720.10	24.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,125,700.00	54,372,834.26	4,752,865.74	8.0
210301	Гэрэл, цахилгаан	12,939,200.00	9,148,984.82	3,790,215.18	29.3
210302	Түлш, халаалт	43,766,500.00	43,005,149.44	761,350.56	1.7
210303	Цэвэр, бохир ус	2,420,000.00	2,218,700.00	201,300.00	8.3
2104	Хангамж, бараа материалын зардал	62,156,600.00	54,113,780.00	8,042,820.00	12.9
210401	Бичиг хэрэг	12,176,200.00	8,827,700.00	3,348,500.00	27.5
210402	Тээвэр, шатахуун	30,090,000.00	28,880,880.00	1,209,120.00	4.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,308,800.00	2,975,000.00	333,800.00	10.1
210405	Хог хаягдал зайлуулах, мэрэгчдийн ариутгал, хортон устгал,	981,600.00	153,600.00	828,000.00	84.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,600,000.00	13,276,600.00	2,323,400.00	14.9
2105	Нормативт зардал	147,002,300.00	117,196,662.00	29,805,638.00	20.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	107,776,200.00	93,026,964.00	14,749,236.00	13.7
210502	Хоол, хүнс	18,526,100.00	17,659,698.00	866,402.00	4.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,700,000.00	6,510,000.00	14,190,000.00	68.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,943,800.00	65,670,399.89	25,273,400.11	27.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	20,129,599.89	9,870,400.11	32.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	382,000.00	-	382,000.00	100.0
210604	Урсгал засвар	60,561,800.00	45,540,800.00	15,021,000.00	24.8
2107	Томилолт, зочны зардал	5,841,000.00	4,980,000.00	861,000.00	14.7
210702	Дотоод албан томилолт	5,841,000.00	4,980,000.00	861,000.00	14.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,139,500.00	4,852,501.00	4,286,999.00	46.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг бусад ажил	1,786,500.00	1,729,500.00	57,000.00	3.2

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	93,960.00	26,040.00	21.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	81,600.00	68,400.00	45.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,517,000.00	1,439,700.00	3,077,300.00	68.1
210807	Газрын төлбөр	20,000.00	7,741.00	12,259.00	61.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,046,000.00	-	1,046,000.00	100.0
2109	Бараа үйлчилгээний зардал бусад				
210901	Бараа үйлчилгээний зардал бусад	11,299,700.00	8,622,600.00	2,677,100.00	23.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг				
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	44,110,200.00	42,847,254.00	1,262,946.00	2.9
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	17,436,000.00	17,436,000.00	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагналыг урамшуулал	28,000,000.00	26,722,500.00	1,277,500.00	4.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
132001	Орон нутгийн төсвөөс	75,447,700.00	70,694,834.00	4,752,866.00	6.3
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,294,910,700.00	1,015,607,844.00	279,302,856.00	21.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,533,000.00	189,464,510.00	(126,931,510.00)	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	62,533,000.00	62,532,974.00	26.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан	26	26		
		1	1		

620002	Гүйцэтгэх ажилтан	18	17		
620003	Үйлчлэх ажилтан	7	8		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,494.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд 8,172.8 мянган төгрөгийн алдаанд залруулга хийлгэлээ.

Залруулгын алдаа:

- ✓ Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр гүйцэтгэлээр тайлагнаагүй 8,172.8 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тус тус 2026.02.13-ны 09 тоот албан бичгээр залруулсан

Аудитаар залруулагдаагүй 24,321.7 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 4 албан шаардлага, 4 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь 24,321.7 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 15,271.2 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тендэрийн худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31-р зүйлийн 31.2-т “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож давтан гарагхгүй байх, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ

5.1.2 НББ, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотоор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн үнэлгээ хэрхэн хийсэн нь тодорхой бус, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй, хөрөнгөд дээд шатны шийдвэргүй өртгийн өөрчлөлт хийсэн, хөрөнгө ангилан бүртгээгүй зэрэг зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 5-р зүйлийн 5.1.2 -д “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 16-р зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож дахин гаргахгүй байх хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ

5.1.3 Сэлбэг хэрэгсэл худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Автомашин засварлах өртөг өндөртэй сэлбэг хэрэгслийн мөнгийг техникийн дүгнэлтгүй, сэлбэг нийлүүлэх гэрээ хийж хувь хүний данс руу шилжүүлсэн ч ажлын гүйцэтгэл байхгүй, ямар машинд юу хийсэн нь тодорхой бус 8,942.0 мнган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 13-р зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож дахин гаргахгүй байх төсвийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлээ

5.1.4 Үндсэн хөрөнгийн засвар үйлчилгээний зардалтай холбоотой

Илрүүлэлт: Орон нутгийн санхүүжилтээс орон сууцны засвар гэж хувь хүний дансруу анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажлын гүйцэтгэл байхгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй мөнгө шилжүүлсэн 12,585.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож дахин гаргахгүй байх хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах, акт, дүгнэлтгүй хөрөнгө зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлээ

5.2 Зөвлөмж

5.2.1 Эм, боох материалын худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Ерөнхий гэрээгээр жагсаалтад орсон эм, эмийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 2,291.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж дотоод хяналтыг сайжруулах

5.2.2 НББ, тайлагналтай холбоотой

*Илрүүлэлт:*НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын тооллогыг чанартай хэрэгжүүлэх, НББ-ийн ОУ-ын стандартын дагуу бараа материалыг ангилан бүртгэх

5.2.3 Цалин хөлс олгох зардалтай холбоотой

Илрүүлэлт: Шөнийн нэмэгдлийг ЭМС-ын 2020 оны А/69 тоот тушаал шийдэрийн дагуу олгоогүй илүү цаг, шөнийн нэмэгдлээ ялгаж бодоогүй, шитгэлийн тооцоо хийж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2 -д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шөнийн нэмэгдэл, илүү цагийн хөлсийг зохих хууль, журмын дагуу олгох, цалинтай холбоотой өглөг, авлагын тооцооны үлдэгдлийг хянаж баталгаажуулах

5.2.4 Бараа материал худалдан авах ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Хоол хүнс, бараа материал худалдан авахдаа сумын нэгдсэн тендер шалгаруулалтанд санал өгөөгүй, худалдан авалтын төлөвлөгөө байхгүй, зах зээлийн үнээс өндөр үнээр хүнс худалдан авсан, нийлүүлж байгаа хүнсний эрүүл ахуй гарал үүслийн бичиг байхгүй хүнс худалдан авсан, нормоос хэтрүүлэн хүнс зарцуулсан 502.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.15.2-д "энэ хуулийн 27.2, 27.5, 27.7.5-д заасан гэрчилгээгүй бүтээгдэхүүн худалдан авах тээвэрлэх, зөөвөрлөхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Хүнсний зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах, гарал үүслийн бичигтэй хүнс худалдан авах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 20 дүгээр сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Архангай аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Өгийнуур ЭМТ	Төсвийн гүйцэтгэлийн тайланг цэвэр гүйцэтгэлээр тайлагнаагүй	1	8,172.9			1	8,172.9	1	8,172.9		
Нийт дүн		1	8,172.9	-	-	1	8,172.9	1	8,172.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		хууль, хяналтын байгууллага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Өгийнуур сумын ЭМТ	Эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуурыг тендэрт шалгарсан аж ахуйн нэгжүүдээс худалдан аваагүй, ААЭМГ/20250102001 дугаартай гэрээний хэрэгжилт хангалтгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй	1	-			1					
	Үндсэн хөрөнгө данснаас хасахдаа төрийн өмчийн албан тоотор хассан боловч албан тоот нь нэр төрлөөр жагсааж хавсралт батлаагүй, хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй, акталсан хөрөнгийг устгах тушаал шийдвэргүй, устгалтын акт үйлдээгүй, үлдэх өртөггүй хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлээгүй, хөрөнгөө ангилж бүртгээгүй	1	-			1					
	Ерөнхий гэрээгээр жагсаалтанд орсон эм эмийн хэрэгсэлийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	2,291.5						1	2,291.5	
	Хоол хүнс, бараа материал худалдан авахдаа сумын нэгдсэн тендер шалгаруулалтанд санал өгөөгүй, худалдан авалтын төлөвлөгөө байхгүй, зах зээлийн үнээс өндөр үнээр хүнс худалдан авсан, нийлүүлж байгаа хүнсний эрүүл ахуй гарал үүслийн бичиг байхгүй хүнс худалдан авсан, нормоос хэтрүүлэн хүнс зарцуулсан	1	502.7						1	502.7	
	Шөнийн нэмэгдлийг ЭМС-ын 2020 оны А/69 тоот тушаал шийдвэрийн дагуу олгоогүй, цалингийн өглөг авлагын тооцоо баталгаажуулаагүй	1	-						1	-	
	Орон нутгийн санхүүжилтээс орон сууцны засвар гэж хувь хүний дансруу анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажлын гүйцэтгэл байхгүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй мөнгө шилжүүлсэн	1	12,585.5				1	12,585.5			
	Автомашин засварлах өртөг өндөртэй сэлбэг хэрэгслийн мөнгийг техникийн дүгнэлтгүй, сэлбэг нийлүүлэх гэрээ хийж хувь хүний данс руу шилжүүлсэн ч ажлын гүйцэтгэл байхгүй, ямар машинд юу хийсэн нь тодорхой бус	1	8,942.0				1	8,942.0			
	НББ-ийн ОУ-ын стандартад нийцүүлэн эм, боох материалын дансанд бүртгэлтэй тусгай зориулалтын материалыг зөв ангилан бүртгээгүй	1	-						1	-	
Нийт дүн	8	24,321.7	-	-	4	21,527.5	4	2,794.2			